



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 06.

Сүхбаатар сум

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.5.3, 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-ын 3.1, 3.2, 2020 оны 141 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.2021 оны 10 дугаар сарын 18, 20-ны өдрүүдэд зохион байгуулагдах төрийн үйлчилгээний байгууллагуудын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Сонгон шалгаруулах комиссын дарга:

Д.Ёндонжамц

-Төрийн албаны Зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Болорзул

-Төрийн албаны Зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Ш.Энхмаа

-Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Ч.Жаргалсайхан

-Боловсролын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Х.Алтантуяа

-Аймгийн Боловсролын газрын ахлах мэргэжилтэн

Техникийн ажлын хэсэг:

Ч.Гандүүрэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Мэдээллийн технологи хариуцсан
Мэргэжилтэн

Ц.Золжаргал

-Боловсролын газрын хүний нөөцийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Сонгон шалгаруулалтыг зарласан хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулан, дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг комиссын дарга Д.Ёндонжамц, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ш.Энхмаа/ нарт даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА